



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 1/14

Мөрөн сум

“Шинэ хөдөө” төсөл”-ийн Трактор, техник тоног
төхөөрөмж хүлээн авах комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинэ хөдөө” төсөл”-ийн хүрээнд “БАГАНАДАНТ” ХХК-аас Мөрөн сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх газар тариалан, байгалийн хадлан тэжээл бэлтгэх зориулалтын трактор, ногоон тэжээлийн үрлэгч, ургамал хамгааллын бодис цацагч хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Ш.Баасандорж Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Гишүүд: Г.Хишигбаатар Хууль эрх зүйн мэргэжилтэн

Ц.Болорцэцэг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан
мэргэжилтэн

2. “Шинэ хөдөө” төсөл”-ийн хүрээнд “БАГАНАДАНТ” ХХК-аас Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгч байгаа газар тариалан, байгалийн хадлан тэжээл бэлтгэх зориулалтын трактор, ногоон тэжээлийн үрлэгч, ургамал хамгааллын бодис цацагчийг хүлээн авахдаа техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг сайтар шалгаж, нэг бүрчлэн акт үйлдэн хүлээн авч Засаг даргын Тамгын газрын нярав (А.Энхтөр)-д актаар хүлээлгэн өгөхийн комиссын дарга (Ш.Баасандорж)-д үүрэг болгосугай.

3. Газар тариалан, байгалийн хадлан тэжээл бэлтгэх зориулалтын трактор, ногоон тэжээлийн үрлэгч, ургамал хамгааллын бодис цацагчийн үндсэн хөрөнгөнд бүртгэж авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ

